



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Мэргэшлийн зэргийн ажлын хэсгийг
байгуулах тухай

Монгол улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 8 дугаар сарын 29-ны А/421, А/115, А/170 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (инженер, техникч, ажиглагч, операторч)-ийн мэргэшлийн зэрэг тогтоох, хамгаалуулах үйл ажиллагаа явуулах, дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах Мэргэшлийн зэргийн ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. “Мэргэшлийн зэргийн ажлын хэсэг”-ийн ажиллах журмыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний дотор боловсруулж, батлуулахыг Мэргэшлийн зэргийн ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Албан хаагчдаас авах шалгалтын сэдэв, тестийг тухай бүр шинэчлэн боловсруулж, шалгаруулалт явуулах үйл ажиллагааг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, дүгнэлт зөвлөмж гаргаж ажиллахыг Мэргэшлийн зэргийн ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

4. Мэргэшлийн зэрэг авсан инженер, техникчдийн нэмэгдлийг тухайн жилийн төсөвтөө тусган олгож байхыг харьяа байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын “Комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2019 оны А/102 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА



Я.ОЮУНЖАРГАЛ

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн
А/172 дугаар тушаалын хавсралт



Мэргэшлийн зэргийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Улсын сүлжээ, уур амьсгалын үйлчилгээний хэлтсийн дарга
Ажлын хэсгийн гишүүд:	Цаг уурын салбарын хөтөлбөрийн хэрэгжилт, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн
	Орчны шинжилгээний салбарын хөтөлбөрийн хэрэгжилт, технологи хариуцсан ахлах мэргэжилтэн
	Урьдчилсан мэдээлэх үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
	Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицүүдийг хариуцсан мэргэжилтэн
	Ус судлалын салбарын хөтөлбөрийн хэрэгжилт, технологи хариуцсан мэргэжилтэн
	Хяналт шинжилгээ, үнэлгээ, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн судалгааны хэлтсийн дарга
	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсийн дарга
	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Гадаргын усны судалгааны хэлтсийн дарга
	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Цаг уурын холбоо, мэдээллийн хэлтсийн дарга
	Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн Хэмжил зүйн хэлтсийн дарга
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн